



## НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянзүрх дүүргийн “Оцело сэргэлт” ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/013/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 11315558 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a> Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 11315558 Цахим хаяг: <a href="mailto:altantsetsegya@audit.gov.mn">altantsetsegya@audit.gov.mn</a> Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: СМД аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал: Д.Гэндэнпэлжээ Утас: 99110699 Цахим хаяг: <a href="mailto:munkhtsatsral@cmdaudit.mn">munkhtsatsral@cmdaudit.mn</a> Аудитор: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: <a href="mailto:tseenyam1202@gmail.com">tseenyam1202@gmail.com</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	2
1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	7
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.5 Санхүүжилт, орлого, зардал, үр дүн .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.1 Ерөнхий зүйл .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.2 Материаллаг байдал .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	<b>Error! Bookmark not defined.</b>
4.4.1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .	<b>Error! Bookmark not defined.</b>
4.5.1 Завсрын аудитын талаар .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн ....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	<b>Error! Bookmark not defined.</b>
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	7
5.1 Төлбөрийн акт .....	7
5.2 Зөвлөмж.....	8
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	9
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл .....	9
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл .....	10
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	10

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МӨАУМХ	Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТББ	Төрийн бус байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМС	Эрүүл мэндийн сайд

## НЭГ. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-03-13 № 600

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ  
ДҮҮРГИЙН ОЦЕЛО СЭРГЭЛТ  
ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА Б.АМАРЖАРГАЛ ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Баянзүрх дүүргийн Оцело сэргэлт ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурьдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Нийслэлийн Баянзүрх дүүргийн Оцело сэргэлт ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 55.2 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Оцело сэргэлт ӨЭМТ нь Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнд ногдох зардлын санхүүжилтээр 526.7 сая төгрөгийн, 4 төрлийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтээр 301.3 сая төгрөгийн, шүдний үзлэгийн санхүүжилтээр 2.0 сая, нийт 830.0 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

### **Аудитын гол асуудал**

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, эрүүл мэндийн ерөнхий газрын санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, иргэнд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 19 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/47 дугаар захирамжаар 95.4 хувь, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах даатгалын гэрээний биелэлтийг 95.2 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

## ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1. ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>1.1 Эргэлтийн хөрөнгө</b>	-	-
1.1.1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	399,634.89	5,006,037.07
1.1.2 Дансны авлага	102,205,078.36	16,647,843.65
1.1.6 Бараа материал	137,117,547.58	181,292,329.95
1.1.11 Эргэлтийн хөрөнгийн дүн	239,722,260.83	202,946,210.67
<b>1.2 Эргэлтийн бус хөрөнгө</b>	-	-
1.2.1 Үндсэн хөрөнгө	51,586,251.40	76,664,429.75
1.2.2 Биет бус хөрөнгө	-	-
1.2.10 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	51,586,251.40	76,664,429.75
<b>1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>291,308,512.23</b>	<b>279,610,640.42</b>
<b>2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	-	-
<b>2.1 Өр төлбөр</b>	-	-
2.1.1 Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1 Дансны өглөг	754,056.33	-
2.1.1.2 Цалингийн өглөг	-	443,574.78
2.1.1.3 Татварын өр	4,821,801.55	-
2.1.1.4 НДШ - ийн өглөг	26,213,180.98	20,707,303.13
2.1.1.8 Урьдчилж орсон орлого	243,487,882.02	-
2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн	275,276,920.88	21,150,877.91
<b>2.2 Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>275,276,920.88</b>	<b>21,150,877.91</b>
<b>2.3 Эздийн өмч</b>	-	-
2.3.1 Өмч:	19,705,437.14	19,705,437.14
2.3.1.1 - төрийн	19,705,437.14	19,705,437.14
2.3.4 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	277,900.40	20,328,567.00
2.3.7 Хуримтлагдсан ашиг	(3,951,746.19)	218,425,758.37
2.3.9 Эздийн өмчийн дүн	16,031,591.35	258,459,762.51
<b>2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>291,308,512.23</b>	<b>279,610,640.42</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1. Борлуулалтын орлого (цэвэр)	-	-
2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
<b>3. Нийт ашиг ( алдагдал)</b>	-	-
4. Санхүүжилтийн орлого	870,742,122.26	830,034,453.90
5. Хүүний орлого	-	12,414.61
6. Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	70,543,192.74	249,095,042.82
8. Бусад орлого	7,363,000.00	8,419,670.50
10. Ерөнхий ба удирдлагын зардал	961,537,365.62	866,692,189.93
11. Санхүүгийн зардал	-	-
<b>18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(12,889,050.62)</b>	<b>220,869,391.90</b>
19. Орлогын татварын зардал	-	-
<b>20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(12,889,050.62)</b>	<b>220,869,391.90</b>
<b>22. Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>(12,889,050.62)</b>	<b>220,869,391.90</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	(1,508,112.66)	(1,508,112.66)
2. Залруулсан үлдэгдэл	19,705,437.14	277,900.40	8,937,304.43	28,920,641.97
3. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(12,889,050.62)	(12,889,050.62)
8. Эхний үлдэгдэл	19,705,437.14	277,900.40	(3,951,746.19)	16,031,591.35
9. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	1,508,112.66	1,508,112.66
10. Залруулсан үлдэгдэл	19,705,437.14	277,900.40	(2,443,633.53)	17,539,704.01
11. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	220,869,391.90	220,869,391.90
15. Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	20,050,666.60	-	20,050,666.60
16. Эцсийн үлдэгдэл	19,705,437.14	20,328,567.00	218,425,758.37	258,459,762.51

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
<b>1.1 Мөнгөн орлогын дүн</b>	<b>776,382,043.90</b>	<b>830,765,041.61</b>
1.1.1 Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	776,382,043.90	830,765,041.61
<b>1.2 Мөнгөн зарлагын дүн</b>	<b>766,902,985.80</b>	<b>827,678,559.43</b>
1.2.1 Ажиллагчдад төлсөн	563,741,370.80	594,908,669.78
1.2.2 Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	62,731,251.00	-
1.2.3 Бараа материал худалдан авахад төлсөн	61,013,932.00	81,693,490.00
1.2.5 Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	79,416,432.00	-
1.2.9 Бусад мөнгөн зарлага	-	151,076,399.65
<b>1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>9,479,058.10</b>	<b>3,086,482.18</b>
<b>2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	-	-
<b>2.1 Мөнгөн орлогын дүн</b>	<b>(9,180,000.00)</b>	<b>1,519,920.00</b>
2.1.1 Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	(9,180,000.00)	1,519,920.00
<b>2.2 Мөнгөн зарлагын дүн</b>	-	-
2.3 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(9,180,000.00)	1,519,920.00
<b>4. Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>299,058.10</b>	<b>4,606,402.18</b>
<b>5. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>100,576.79</b>	<b>399,634.89</b>
<b>6. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>399,634.89</b>	<b>5,006,037.07</b>

## ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 55,172.0 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>1</sup> илэрснээс 7,884.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг давтан гаргуулахгүй байх 47,287.3 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн, нийцлийн аудиттай холбоотой 98,460.4 мянган төгрөгийн зөрчил илэрч 1 албан шаардлага хүргүүлэн,.

Нийт илрүүлсэн 55,172.0 мянган төгрөгийн санхүүгийн тайлагналтай холбоотой зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 3.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 351,046.2 мянган төгрөгийн 4 алдаа<sup>2</sup> илэрснийг аудитын явцад залруулга хийлгэж, баталгаажуулсан. Үүнд:

- Тус байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй 7,700.0 мянган төгрөгийн дефибрилятор, 60,500.0 мянган төгрөгийн Эхо аппаратыг эрх бүхий байгууллагын шийдвэргүй данснаас хассан;
- Тайлант оны эцэст ЭМДЕГ-аас 7701.5 мянган төгрөгийн санхүүжилт, ХХОАТ-ын 745.7 мянган төгрөгийн авлагыг тайланд тусгаагүй, ажиллагсдаас суутгасан ХХОАТ-ыг 6,688.6 мянган төгрөгөөр илүү төлсөн авлагыг өглөгөөр хасах тэмдэгтэй санхүүгийн тайланд тусгасан;
- Урьдчилж орсон орлого дансанд бүртгэлтэй 241,979.8 мянган төгрөгийн хөрөнгийн тайлант онд ногдох элэгдлийн зардлыг тооцож хасалт хийгээгүй;
- Өглөгийн дансанд гэрээт 2 ажилтанд өгөх 636.1 мянган төгрөгийн өглөгийг тайланд тусгаагүй, байгууллагад төлөх өглөг дансанд урсгал засварын материалын орлого, зарцуулалтыг давхардуулан тайлагнаснаас 25,094.5 мянган төгрөгийн өглөг илүү тусгагдсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2-д "Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх" заалттай зөрчилдөж байгаа бөгөөд санхүүгийн тайлагналын "үнэлгээ ба хуваарилалт", "ангилал", "иж бүрэн байх", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

### 3.2 Төлбөрийн акт

- Тайлант онд цалин, ээлжийн амралтын олговрыг 4,536.7 мянган төгрөгөөр илүү олгож, урамшууллаас 3,348.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутган тооцоогүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-г "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", "Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал,

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<sup>2</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна”, 7.1.1-д “ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого”, 21.2.4-д “энэ хуулийн 15.1, 16 дугаар зүйл, 17.1.2, 17.1.3-т зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” заалтад заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Илүү олгосон цалин урамшуулал, суутган тооцоогүй татварын нийт 7,884.7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 3.3 Албан шаардлага

- Тайлант онд эм, эмнэлгийн хэрэгслийн 98,460.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авахдаа худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.1-д “Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө”, 10 дугаар зүйлийн 10.2-т “Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно” гэсэн заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Бараа материал худалдан авахдаа худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

### 3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой асуудал:

**Илрүүлэлт-1.** Тус байгууллагын нярав нь эмийн тайланг сар бүр гарган, нягтлан бодогчоор хянуулаагүй, 47,287.3 мянган төгрөгийн зарлагыг нэгтгэн гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна. гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын “Толилуулга”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Эм эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтын тайланг сар бүр гарган, үлдэгдлийг баталгаажуулж, санхүүгийн тайланг зөв илэрхийлэн тайлагнаж байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг НТАГ-т 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй нийт 68,200.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэргүй данснаас хассан.	1	68,200.0	1	68,200.0			1	68,200.0		
Тайлант оны эцэст нийт 15,135.8 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй.	1	15,135.8	1	15,135.8			1	15,135.8		
Урьдчилж орсон орлого дансанд бүртгэлтэй 241,979.8 мянган төгрөгийн хөрөнгийн тайлант онд ногдох элэгдлийн зардлыг тооцож хасалт хийгээгүй.	1	241,979.8	1	241,979.8			1	241,979.8		
Өглөгийн дансанд гэрээт 2 ажилтанд өгөх 636.1 мянган төгрөгийн өглөгийг тусгаагүй, урсгал засварын материалын орлого, зарцуулалтыг давхардуулан 25,094.5 мянган төгрөгийн өглөг илүү тусгагдсан байна.	1	25,730.6			1	25,730.6	1	25,730.6		
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>351,046.2</b>	<b>3</b>	<b>325,315.6</b>	<b>1</b>	<b>25,730.6</b>	<b>4</b>	<b>351,046.2</b>		

#### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд ажиллагсдад цалин, ээлжийн амралтын олговрыг 4,536.7 мянган төгрөгөөр илүү олгож, урамшууллаас 3,348.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутган тооцоогүй байна.	1	7,884.7	1	7,884.7				
Тус байгууллагын нярав нь эмийн тайланг сар бүр гарган, нягтлан бодогчоор хянуулаагүй, 47,287.3 мянган төгрөгийн зарлагыг нэгтгэн гаргасан.	1	47,287.3					1	47,287.3
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>55,172.0</b>	<b>1</b>	<b>7,884.7</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>47,287.3</b>

#### 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд эм, эмнэлгийн хэрэгслийн 98,460.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авахдаа худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна.	1	98,460.4			1	98,460.4		
Шилэн дансны цахим хуудсанд улирал бүр мэдээлэх нийт 924,056.0 мянган төгрөгийн орлогын 4 мэдээллээс 1 улирлын мэдээллийг хугацаа хоцроосон, үнийн дүнг өссөн дүнгээр 85,193.9 мянган төгрөгийг дутуу мэдээлсэн байна.	1	-			-	-	1	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>98,460.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>98,460.4</b>	<b>1</b>	<b>-</b>

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл**

А	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
1	ОНӨҮГ		1			1			
	<b>НИЙТ</b>		<b>1</b>			<b>1</b>			



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 05 дугаар сарын 15

№ 135/БМАА 0255

Улаанбаатар хот

НТАГ-2026/013/НА-СТА-ОНӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Баянзүрх дүүргийн Оцело Сэргэлт Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд цалин, ээлжийн амралтын олговоргыг 4,536.7 (дөрвөн сая таван зуун гучин зургаан мянга долоон зуун) төгрөгөөр илүү олгож, урамшууллаас 3,348,000.0 (гурван сая гурван зуун дөчин найман мянган) төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутган тооцоогүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", "Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна", 7.1.1-д "ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого", 21.2.4-д "энэ хуулийн 15.1, 16 дугаар зүйл, 17.1.2, 17.1.3-т зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалтад заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон", 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Илүү олгосон цалин урамшуулал, суутган тооцоогүй татварын 7,884,700.0 (долоон сая найман зуун наян дөрвөн мянга долоон зуун) төгрөгийг Нийслэлийн Баянзүрх дүүргийн Оцело Сэргэлт Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга (Б.Амаржаргал), нягтлан бодогч (Ж.Мөнхтуяа) нараар төлүүлж, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь

<sup>1</sup> Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар


1426110198

- НТАГ.хүү торгуулийн орлогын данс MN440090100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэхийг Нийслэлийн Баянзүрх дүүргийн Оцело Сэргэлт ӨЭМТ-ийн дарга (Б.Амаржаргал), нягтлан бодогч (Ж.Мөнхтуяа) нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
“СМД АУДИТ” ХХК-ИЙН АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ  
Я.АЛТАНЦЭЦЭГ  
А.ЦЭЭНЯМ



<sup>1</sup> Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 270/Б1970235

Улаанбаатар хот

НТАГ-2026/013/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Баянзүрх дүүргийн Оцело Сэргэлт Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 98,460,393.0 (ерэн найман сая дөрвөн зуун жаран мянга гурван зуун ерэн гурван) төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1.Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтыг хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулаагүй зөрчлийг зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Оцело Сэргэлт Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Б.Амаржаргал, нягтлан бодогч Ж.Мөнхтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
"СМД АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ  
Я.АЛТАНЦЭЦЭГ  
А.ЦЭЭНЯМ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,  
Г корпус, 5 давхар

1426090434